



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

ХОТЫН СТАНДАРТ,
ХЯНАЛТЫН ГАЗАР

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

"2.Нийслэлийн нутаг дэвсгэрт холбогдох эрх бүхий байгууллагаас барилгын ажлын зөвшөөрөл авалгүй барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэсэн иргэн, хуулийн этгээдүүдэд цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Хот байгуулалтын тухай, Барилгын тухай, Газрын тухай болон холбогдох хууль, тогтоомж, барилгын норм ба дүрмийг зөрчиж барьсан иргэн, хуулийн этгээдийн барилга, байгууламжийг албадан буулгах арга хэмжээний талаар зохих хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг хангуулахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Ж.Сандагсүрэн), Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга), Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам), Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг), Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (Г.Цэргийнхүү), Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т;

2.Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 211 дүгээр тушаалд заасан онцгой төвөгшлийн ангилалд хамаарах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын барилга, байгууламжийн зөрчлийг арилгуулахаар холбогдох арга хэмжээг авахуулах талаар асуудлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Ж.Сандагсүрэн), Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т;

3.Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтад заасан Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээгүй барилга, байгууламжийн ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэж буй иргэн, хуулийн этгээдийг барилгын бүтээц, буурь хөрсний хүчдэл-хэв гажилтын одоогийн байдалд дүгнэлтийг хийлгэсний үндсэн дээр Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолын дагуу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гаргуулан холбогдох шийдвэрийг гаргуулсны дараа барилгын зөвшөөрлийн гэрчилгээг олгохыг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т;

4.Барилга, байгууламжийг гүйцэтгэж дуусган ашигласан иргэн, хуулийн этгээдийг барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ авсны дараа Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу байнгын ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т;

1110200240

5. Зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Ж.Сандагсүрэн)-д тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

